



**ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ**

2017 оны 07-сарын 18 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

**Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн төсөл
сонгон шалгаруулах хугацааг сунгах тухай**

Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7.1, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалт, Газрын тухай хуулийн 22¹ дугаар зүйлийн 22¹.1. дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль, Үндэсний их баяр наадам тохиож, амралтын өдрүүд урт байсантай холбогдуулан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2017 оны 05 сарын 26-ны “Газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт явуулах тухай” А/22 тоот захирамжийн төслийн материал хүлээн авах хугацааг 15 хоногоор хойшлуулж, 2017 оны 08 сарын 07-ны өдрийн 12 цаг хүртэл сунгасугай.

2. Тус захирамжийг олон нийтэд мэдээлэх, Газар эзэмшүүлэх, ашиглуулах төслийн материалыг зохих журмын дагуу хүлээн авах ажлыг Газрын асуудал эрхэлсэн мэргэжилтэн Ш.Амартүвшинд үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн Ажлын албаны дарга М.Энхбаярт даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.БАТНАСАН

000110